

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

ХӨХ БИШРЭЛТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ REN DEWEN

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ЦАГААН ДЭЛ” ЖОНШ БАЯЖУУЛАХ
ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН:

ХӨХ БИШРЭЛТ ХХК-ИЙН

ҮЙЛДВЭРИЙН ДАРГА Ц.АРИУНЦЭЦЭГ

АГУУЛГА

Агуулга	2
Зургийн жагсаалт	2
Хүснэгтийн жагсаалт	2
Товчилсон үгийн тайлбар	3
1. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Нэр, байршил	4
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл	5
1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал	5
1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал	6
1.5. Үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж	6
1.6. Баяжуулах үйлдвэрийн технологийн дараалал	7
1.7. Тухайн жилийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө	8
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	9
2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог	9
2.2. Уур амьсгал	9
2.3. Гадаргын ус	9
2.4. Газрын доорх ус	9
2.5. Хөрсөн бүрхэвч	10
2.6. Ургамлан нөмрөг	10
2.7. Амьтны аймаг	10
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	11
3.1. Газрын гадарга, хэвлий	11
3.2. Агаарын чанар	11
3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус	11
3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг	11
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	12
5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20
5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	22
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
5.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	31
5.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	34

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил	5
Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем	6
Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн холболтын схем	7
Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн схем	8

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2024 оны БОМТ хэрэгжүүлэх зардлын хэмжээ	13
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	22

Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	28
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	32
Хүснэгт 11. ОХШХ-ийн хүрээнд хийгдэх ажлууд	33
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- БОАЖЯ – Байгаль орчин аялал жуулчлалын яам
МХГ – Мэргэжлийн хяналтын газар
ЭБМЗ – Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
ТЭЗҮ – Техник эдийн засгийн үндэслэл
БОМТ – Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОЯБ – Биологийн олон янз байдал
УТХГ – Улсын тусгай хамгаалалттай газар
ОХШХ – Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
БОННҮ – Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

1. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Жонш баяжуулах үйлдвэр” нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт Монголросцветмет ХХК-ний ашиглаж байсан Хамар-Усны хайлуур жоншны ордын ил уурхайгаас олборлож гаргасан балансын бус жоншны хүдрийн овоолгыг түшиглэн жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан бөгөөд 2021 онд “Сити-Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайшаншин юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэж жилд бүрэн хүчин чадлаараа 300.0 мян.тн хүдэр боловсруулан баяжуулж, ФФ97 маркийн 76.3 мян.тн жоншны баяжмалыг гаргах хүчин чадалтайгаар ажиллахаар ТЭЗҮ /тодотгол/-ыг “Ертөнцийн зүг” ХХК боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ашигт малтмал газрын тосны газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 11-р сарын 23-ны өдрийн Т/20-11-03 тоот дүгнэлтээр баталгаажуулжээ.


“Хөх бишрэлт” ХХК нь “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2017 онд “Ашид ананда” ХХК-иар хийлгүүлж, 2018 онд “Ашид ананда” ХХК-иар нэмэлт тодотголыг тус тус хийлгэж, БОАЖЯ-р батлуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618-р тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч “Хөх Бишрэлт” ХХК нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж, тус журмын дагуу байгуулагдсан ажлын хэсэгт дээрх төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлүүлж 91%-ийн үнэлгээ авсан болно /Хавсралт 1. БОМТ-2023-ийн хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн хуудас/.

Төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол улсын хууль, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, өмнөх жилийн ажлын хэсгийн дүгнэлтээр гарсан зөвлөмж зэргийг удирдлага болгож, төслийн хэмжээнд 2024 онд хийгдэх үйл ажиллагаатай уялдуулан боловсруулав.

1.1. Нэр, байршил

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Цагаан Дэлийн жонш баяжуулах үйлдвэр” төсөл нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 345 км, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн тийш 50 км, Иххэт сумаас баруун тийш 5 км-т оршиж байна.



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр:	“Хөх Бишрэлт” ХХК
Аж ахуйн нэгж бүртгэлийн дугаар:	9019078088
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:	Гадаад худалдаа
Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг:	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо, Сайн ноён хан Намнансүрэнгийн гудамж, 35-3 тоот
Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Гүйцэтгэх захирал REN DEWEN, 96620509, huhbishrelt.5878@yahoo.com
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Үйлдвэрийн дарга Ц.Ариунцэцэг, 99153477, huhbishrelt.5878@yahoo.com

1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал

Жонш баяжуулах үйлдвэрийн дэд бүтэц, зохион байгуулалтийн хувьд түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бутлан ангилах хэсэг, нунтаглан баяжуулах хэсэг, баяжмал шүүн хатаах хэсэг, баяжмал савлах, хадгалах хэсэг, хаягдлын аж ахуй, засвар үйлчилгээний хэсэг, эргэлтийн усны сав, цэвэр усны худаг, ус дамжуулах насос, урвалж бодисын агуулах, цахилгаан хангамжийн хэсэг, хяналтын лаборатори, уурын зуухны хэсэг, ажилчдын байр гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.


1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал

Цагаан Дэл жонш баяжуулах үйлдвэр нь жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан. 2021 онд төслийн ТЭЗҮ-нд нэмэлт тодотгол хийгдэж “Сити Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайншаншин Юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэн жилд 300.0 мян.тонн хүчин чадалтайгаар ФФ97 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 2017 онд бүрэн хэрэгжиж, 2018 оноос эхлэн бүтээгдэхүүн гаргах, үйл ажиллагаа эхэлсэн байдаг.


1.5. Үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж

Жоншны хүдэр боловсруулалтын технологийн процесс дараах схемийн дагуу явагдана. Үүнд:

- Хүдрийг 5.0 мян.м2 талбайд овоолж дундажлах;
- Том бутлалтын хэсэг
- Дунд бутлалтын хэсэг (хяналтын шигшилттэй)
- Нунтаглалт (ангилалтын битүү циклээр ажиллах)
- Үндсэн флотаци, хяналтын флотаци, 6 үе шаттай цэвэрлэгээний флотаци,
- Баяжмалын өтгөрүүлэлт, шүүх, хатаах
- Хаягдлын аж ахуй зэрэг процессоос бүрдэнэ.



Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем



Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн холболтын схем

1.6. Баяжуулах үйлдвэрийн технологийн дараалал

Хүдэр бутлалт:

Баяжуулах үйлдвэрийн хүдэр бутлах хэсэг нь 2 шатны бутлуур, 1 шатны шигшүүрээс бүрдэнэ. Анхдагч хүдрийг хяналтын шигшилтэй 2 шатны бутлалтын схемээр буталж хүдэрийн ширхэглэлийг 12мм болгоно.

Анхдагч хүдрийн овоолгоос утгуурт ачигчийн тусламжтай хүдрийг хүлээн авах бункерт тэжээх бөгөөд бункерын доор суурилагдсан хавтант тэжээгүүр нь нэгдүгээр шатны хацарт бутлуурыг тэжээнэ. Нэгдүгээр шатны хацарт бутлуурын хүлээн авах хүдрийн хамгийн том ширхэглэл -400 мм байх бөгөөд бутлуураас -80 мм-ийн ширхэглэлтэй хүдэр гарна.

Хяналтын шигшилтийн зорилго нь бутлагдсан хүдрийн ширхэглэлд хяналт тавих болон хоёрдугаар шатны бутлуурт орох шаардлагагүй хүдрийг ялгана. Бутлах цехэд ажиллах шигшүүрийн торны нүхний хэмжээ 15 мм байна. Хяналтын шигшүүрийн торны дээд ангийг (+12 мм-ийн анги) хоёрдугаар шатны бутлуур (1-р шугам хацарт бутлуур, 2-р шугам конусан бутлуур)-т өгөх бөгөөд бутлуураас гарах хүдрийн ширхэглэл -12мм байна.


Хүдэр жигдрүүлэлт:

Баяжуулах процесст орж байгаа хүдрийн шинж чанар, хүдэр дэх ашигт болон хорт хольцын агуулгын өөрчлөлт нь үйлдвэрийн хүчин чадал, ажлын горим, баяжмалын чанар, бүтээгдэхүүний гарц, минерал авалт зэрэг нөлөөлдөг. Ийм учраас баяжуулах үйлдвэрийн технологийн процессыг хэвийн жигд явуулах зорилгоор хүдэр жигдрүүлэлтийн ажил хийгддэг. Жонш олборлогчдоос нийлүүлж буй түүхий эдийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдэр жигдрүүлэх талбайд зөөвөрлөн авчирч, жоншны агуулга болон хүдэр дэх карбонатын агуулгаас хамааруулан үечлэн овоолго байгуулах замаар хүдрийг жигдрүүлэн баяжуулахад бэлтгэн хадгална. Хүдрийг холих үедээ хүдрийн бүтцийн чанарыг судлах шаардлагатай.

Баяжуулалт:

Баяжуулах үйлдвэр нь түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бутлан ангилах хэсэг, нунтаглан баяжуулах хэсэг, баяжмал шүүн хатаах хэсэг, баяжмал савлах, хадгалах хэсэг, хаягдлын аж ахуй, засвар үйлчилгээний хэсэг, эргэлтийн усны сав, цэвэр усны худаг, ус дамжуулах насос, урвалж бодисын

агуулах, цахилгаан хангамжийн хэсэг, хяналтын лаборатори, уурын зуухны хэсэг, ажилчдын байр контор зэргээс бүрдэнэ.



Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн схем

1.7. Тухайн жилийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Цагаан Дэл жонш баяжуулах үйлдвэр нь жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан. 2021 онд төслийн ТЭЗҮ-нд нэмэлт тодотгол хийгдэж “Сити Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайншаншин Юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэн жилд 300.0 мян.тонн хүчин чадалтайгаар ФФ97 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. Бид үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааг батлагдсан ТЭЗҮ-н дагуу явуулж байна.

Үйлдвэрийн 2024 оны ашиглалтын төлөвлөгөөнд 39.5 мян.тн жоншны хүдэр боловсруулан баяжуулж 17.61 мян.тн ФФ97 маркийн баяжмал гаргахаар тусгасан болно.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Цагаан Дэлийн жонш баяжуулах үйлдвэр” төсөл нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 345 км, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн тийш 50 км, Иххэт сумаас баруун тийш 5 км-т оршиж байна. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болох Дорноговь аймгийн Иххэт сум нь Төв Азийн их цөл өндөрлөгийн умард хаяанд байрладаг. Төсөл хэрэгжих сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий заримдаг цөлийн бор саарал, цайвар бор, хужир мараат хөрстэй, хялгана, харганат цөлийн хээр алаг өвст ургамалтай, байгалийн хээржүү цөл хамаарна. Төсөл байрлах талбай нь Дорноговь аймгийн Иххэт сум нь далайн түвшнээс 937-1380 м өргөгдсөн байна.

2.2. Уур амьсгал

“Хөх Бишрэлт” ХХК-ийн Жонш баяжуулах үйлдвэр байрлах Дорноговь аймаг нь уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар мужид багтана. Манай орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их агууриг 33.6 градус, өвөлдөө хүйтэх боловч зундаа аагим халуун болно.

Жилийн явцад агаарын температур хамгийн их утга нь 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дугаар сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур +22.1°C хамгийн хүйтэн 1 дугаар сарын дундаж агаарын температур -19.1°C байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур +33.5°C хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага температур -31.1°C хүрч хүйтэрсэн байна.

2.3. Гадаргын ус

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт хамаарна. Төслийн талбай орчим гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, төслийн талбайн ойр орчимд байнгын урсацтай гол горхи болон нуур байхгүй. Умард говийн усны сав газрын хүрээнд гадаргын усны нөөц хомс тул сав газар дахь жижиг нуур, тойром, гол горхиудад ус судлалын байнгын харуул бүхий ажиглалт, хэмжилтийн сүлжээ байхгүй. Сав газрын гадаргын усны сүлжээний нягтшил буюу 1 км² талбайд ногдох голын урт нь маш бага (0.01км/км²) бөгөөд сав газрын хэмжээнд хамгийн их урсац бүрдэлт нь сав газрын хойд, баруун хойд хэсэгт ажиглагдана.

2.4. Газрын доорх ус

“Хөх бишрэлт” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төсөл байрлах нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт хамаарах ба энэхүү сав газрын гидрогеологийн нөхцлийн гол онцлог нь төв азийн гадагш урсгалгүй ай савд багтах, ихэнх нөхцөлд хоорондоо нарийн хүзүүвчүүдээр холбогдсон, олон төрлийн ус агуулагч үе, давхарга, бүрдэл, ан цавын усжсан бүс бүхий газрын доорх усны сав газар юм. Газрын доорх усны тэжээгдлийн бүс нь янз бүрийн насны өгөршил, тектоникийн хагарал, эвдрэл, ан цавшилт эрчимтэй өртсөн түрмэл (интрузив), бялхмал, тунамал, хувирмал үндсэн чулуулгаас зонхилж тогтсон байна.

Газрын доорх усны хуримтлал болон хөлийн бүс нь дөрөвдэгч, голоцены настай аллюви, пролюви, нуур, салхины гаралтай сэвсгэр хурдасны зузаалаг, дахь уст үе, давхарга, неоген, палеоген, цэрдийн настай тунамал хурдасны зузаалаг дахь нүх сав-давхраасын уст давхарга, бүрдэл, юра, триас, пермийн настай эх газрын гарал үүсэлтэй чулуулгийн зузаалаг дахь ан цавын усжсан бүсээс бүрдсэн хөндий, хотгор, хоолой зэрэг нам доор газрууд хамрагдана.

Газрын доорх усны хөдөлгөөний ерөнхий зүй тогтол нь өндөрлөг хэсгээсээ нам дор газар луугаа чиглэх ба бага зузаантай дөрөвдэгчийн настай сэвсгэр хурдас нь өөрийнхөө доор байрлах бусад ус агуулагч давхарга руу газрын доорх усыг нэвтрүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Сав газрын өндөрлөг хэсгүүдээр

тархсан үндсэн чулуулгийн массивын гадаргуу орчимд ихэвчлэн экзогенний гарал үүсэлтэй харьцангуй жигд бус, эмх замбараагүй тархалттай ан цавшилын бүс үүссэн байдаг. Эдгээр ан цавын бүсэд газрын доорх ус тодорхой хэмжээгээр хуримтлагдах боломжтой боловч биеэ даасан уст давхарга ховор ихэвчлэн тэжээлийн гадаад мужийн үүргийг гүйцэтгэнэ.

2.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд хамаарах газар нь 1230-1260 метрийн үнэмлэхүй өндөртэй нам уулс болон гүвээрхэг тэгшивтэр талархаг газарт байрлана. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар хархүрэн, хүрэн хөрс зонхилон тархсан Бор өндөр уул баяны тойрогт хамрагддаг. Энд өргөрөгийн бүсийн зүй тогтолтой уялдан хүрэн хөрс бөгөөд эзэмшил талбайн зүүн хэсэг дэх сайрын гольдролд ул хөрсний усны түвшин, эрдэсжилтээс хамаарч сайрын сул хөгжилтэй хөрс багахан газарт тархдаг.

2.6. Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь ургамал-газарзүйн тойргоор Дундаж Халхын хээрийн тойрогт байрлах боловч Дорно-Говийн цөлөрхөг хээрийн тойрогт шилжих хил залгаа бүс нутагт байрлаж байна. Энд хойноосоо Дундад халхын хээрийн үет ургамлын төлөөлөл өмнөөсөө цөлөрхөг хээрийн жижиг сөөг сөөгөнцөр ургамлын төлөөлөл тохиолдох онцлогтой. Төслийн талбай нь Монголын төв хэсгийн боржин бүхий бэсрэг уулс, ухаа гүвээрхэг толгод хоорондын нарийн хотос хоолойд байрлаж байна.

Ерөнхийдөө төслийн талбай орчим нь толгодорхог хэсгээр харгана-үетэн ургамлан бүлгэмдэл харин нам хотос, хажуу хэсгээр харгана-үетэн-алаг өвст, гэсэн 2 үндсэн ургамлан бүлгэмдэл тохиолдож байна. Уг ургамлан бүлгэмдлүүдийг дагаж, Гялгар дэрс (*Achnatherum splendens*), Хазааргана (*Cleistogenes squarrosa*), Ширэг улалж (*Carex duriuscula*), Крылов хялгана (*Stipa Krilovi*), Агь (*Artemisia frigida Willd*), Имт гичгэнэ (*Potentilla bifurca*), Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis*), Жижиг навчит харгана (*Garagana micropylla*), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla*), Манан хамхаг (*Bassia dasyphylla*), Аммоны сэдэргэнэ (*Convolus ammoni*), Бага хургалж (*Eragrostis minor*) Шүлхий Шарилж (*Artemisia pectinata*), зэрэг ургамлууд зонхилогч болон дэд зонхилогчоор ургана.

2.7. Амьтны аймаг

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орчинд хуурай хээр болон хуурайдуу хээрийн экосистем тархсан.

Амьтны аймгийн хувьд цагаан зээр, үлийн цагаан оготно, монгол чичүүл, монгол тарвага, хярс, мануул, идлэг шонхор, хээрийн бүргэд, шилийн сар, монгол болжмор зэрэг хөхтөн болон шувууд төлөөлөх зүйлд тооцогдоно.

Хөхтөн амьтан: Төслийн талбай орчим Монгол улсын улаан данс (2006)-ны ховордлын зэргийн үнэлгээгээр “устаж болзошгүй” зүйлийн ангилалд бүртгэгдсэн 1 зүйл, “эмзэг” 1 зүйл, “ховордож болзошгүй” 5 зүйл хөхтөн амьтан тус тус оршин амьдарч байна. Нөгөө талаас “мэдээлэл дутмаг” ангилалд бүртгэгдсэн 5 зүйл хөхтөн амьтад байна.

Мөлхөгчид: Мөлхөгчдөөс энэ бүс нутагт 3 овог, 3 төрөлд хамаарах 3 зүйл тархдаг ажээ. Энд тархсан гүрвэл болон могойн зүйлүүд нь Монгол орны хэмжээнд түгээмэл тархацтай юм. Мөлхөгч амьтдын хувьд газрын тос олборлолт, хайгуулын үед хөнөөгдөх эрсдэл харьцангуй бага бөгөөд энэ талбайд тоо толгойн хувьд элбэг, тархацын хувьд түгээмэл амьтад тархсан байна.

Шувуу: Төслийн талбай орчим 123 зүйлийн шувуу тохиох боломжтой ба тус бүс нутагт хээрийн шувууд зонхилон тархсан байдаг. Шувууны аймгийн хувьд зусаж өндөглөдөг ба хэсэгчлэн нүүдэг шувууд зонхилох (103 зүйл) бөгөөд жилийн турш суурин амьдардаг 19 зүйл, зөвхөн өвөл ирээд буцдаг цөөн шувуу (1 зүйл) байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслөөс байгаль орчны бүрдэл хэсгүүд болох газрын гадарга, хэвлий, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамал зэрэгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг БОННУ-ний тодотгол тайланд нарийвчлан тусгаж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байдаг.

3.1. Газрын гадарга, хэвлий

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүдийг товч дурдвал:

- Барилгажилт, дэд бүтэц барьж байгуулах болон баяжуулах үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хэвлийн хэлбэр дүрс өөрчлөгдөх
- Төслийн үйл ажиллагааны улмаас хаягдлын талбай, овоолгын талбай тэлэх, барилга байгууламжууд нэмж байгуулах, шинээр зам гаргах.

3.2. Агаарын чанар

Жигдрүүлсэн хүдрийг бункерт тэжээх, 2 шатны бутлуураар бутлах, шигших, хүдэр хадгалах талбайд туузан дамжуулгаар буулгах зэрэг бүхий л шат дамжлагуудаас тоос тоосонцор үүсдэг. Мөн идэвхтэй овоолго, эвдрэлд орсон талбай зэргээс хуурай салхитай үед тоос шороо агаарт дэгдэж салхины дагуу тархах зэрэг нь төслийн үйл ажиллагаанаас агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл болж болзошгүй юм.

3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл нь хаягдлын далан болон химийн бодисын агуулхаас бохирдуулагч бодис алдах, шатах тослох материал, хатуу болон шингэн хог хаягдлын талбайгаас бохирдол үүсэх зэрэг юм.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл нь шинээр шимт хөрсний хуулалт хийгдэх газарт үүсэх хөрсний эвдрэл ба бүтэцийн алдагдал, үйлдвэрийн дотоод замаар зорчих техникийн нөлөөгөөр үүсэх өнгөн хөрсний талхагдал, төслийн талбайгаас үүсэх тоосонцорын тархалт гэсэн өдөр тутамд үүсч байгаа сөрөг нөлөөллөөс гадна авто зогсоол ба засвар үйлчилгээний талбай орчимд үүсэх шатах тослох материалын цэгэн бохирдол, ахуйн гаралтай органик ба хатуу, шингэн хог хаягдлаас үүдэлтэй механик болон нянгийн бохирдол гэсэн болзошгүй сөрөг нөлөөллүүд байна.

3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг

Жонш баяжуулах үйлдвэрийн 2022 онд хийгдсэн БОННУ-ний тодотгол тайланд төслийн талбай орчим Монгол улсын улаан данс (2006)-ны ховордлын зэргийн үнэлгээгээр “устаж болзошгүй” зүйлийн ангилалд бүртгэгдсэн 1 зүйл, “эмзэг” 1 зүйл, “ховордож болзошгүй” 5 зүйл хөхтөн амьтан тус тус оршин амьдарч байгаа талаар тусгасан байдаг. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь дуу чимээнээс амьтад дайжих, зам, дэд бүтэц байгуулснаас үүдэн амьдрах орчин алдагдах зэрэг болно.

Харин ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь дэд бүтэц, барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүдэн ургамлан нөмрөг талхлагдах юм.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Хөх Бишрэлт” ХХК нь жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явагдах газар нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг боломжит хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн талуудын оролцоог хангасан хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж мөн нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

Бид үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна,

Үйлдвэрийн 2024 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний гол зорилт нь жонш баяжуулалтын үйл ажиллагаа, химийн бодис тээвэрлэх, хадгалах болон ашиглах, хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх зэрэг үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

Бид 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгож, үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөсөн болно.

Бид үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ нь тусгай зөвшөөрөлтэй талбай, түүнээс гадна ОХШХ-т багтсан хяналт шинжилгээний цэгүүд хамаарна.

5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баяжуулах үйлдвэрийн 2024 оны БОМТ-ний гол зорилгод үйл ажиллагаанаас үүсэх, гарч болзошгүй эрсдэлүүдийг бүрэн тодорхойлж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршиж байгаа болно.

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэргийг агуулсан 66 төсөвт болон төсөвт бус ажилтай болно.

Баяжуулах үйлдвэрийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардалд **66,00,000 (Жаран зургаан сая)** төгрөг төсөвлөгдсөн.

Хүснэгт 1. 2024 оны БОМТ хэрэгжүүлэх зардлын хэмжээ

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал	Нэмэлт тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	22,500,000	
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардлаас	
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	300,000	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Төлөвлөөгүй	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10,000,000	
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	5,000,000	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15,200,000	
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	800,000	
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	13,200,000	
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	Үйл ажиллагааны зардлаас	
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төг		66,000,000	

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” түүний хавсралтад төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваан агаар, хөрс, гадаргын ба газрын доорх ус, амьтан, ургамал, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн энэхүү төлөвлөгөөг боловсрууллаа.

БОННУ-нд тодорхойлсон байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл мөн төслийн 2024 оны үйл ажиллагаатай уялдуулан гол болон болзошгүй 11 сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв. Төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээ бүрд тухайн сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, хэмжих нэгж, шаардагдах төсөв, баримтлах стандарт, хуулийн шаардлагыг тусгасан болно.

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажил	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Аргачлал, стандарт, эрх зүйн зохицуулалт
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Агаар									
1	Агаарын бохирдол	Нам даралтын халаалтын зуухнаас гарах утаанд агаарт ялгарах бохирдлын хэмжээг тодорхойлуулах, агаарын бохирдуулсны төлбөрийг төлөх	Баяжуулах үйлдвэр	Үйл ажиллагааны зардлаас				Төлөвлөгөөт жилд	Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хууль
2	Олон салаа зам гаргах	Олон салаа зам гаргахаас сэргийлэх шаардлагагүй замыг хаах, тэмдэг байрлуулах, хурдны хязгаар тогтоох		ш	50,000	50	2,500,000	Төлөвлөгөөт жилд	
3	Машин, техникийн хөдөлгөөнөөс тоос босох	Баяжуулах үйлдвэрийн тоос босох боломжтой байршлуудад тоосны болон агаарын бохирдлын хэмжилтийг тогтмол хийх. Стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх		давтамж	250,000	12	3,000,000	Улирал тутам	Агаарын тухай хууль
4	Суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмж гарах хий агаарын чанарт нөлөөлөх	Суурин тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийх	Хүдэр бутлах төхөөрөмж орчим	Тоос босох талбай	Дотоод үйл ажиллагаа		5000 км тутамд		
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Хөрс									
5	Тос, тосолгоо, түлш, хөрсөнд асгарч хөрсийг бохирдуулах	Хөнгөн тэрэгний засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийх	Хөнгөн тэрэг	Дотоод үйл ажиллагаа				5000 км тутам	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
6		ШТС-г байнгын хяналтад байлгаж өдөр тутмын үзлэг хийх	ШТС	Дотоод үйл ажиллагаа				Өдөр тутам	
7		Тоног төхөөрөмж, хөнгөн тэрэг, технологийн хүнд машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын хөрсөнд нэвчилт үүсгэхгүй талбайд хийх	Хөнгөн тэрэг, машин механизм	Дотоод үйл ажиллагаа				Өдөр тутам	
8		Асгаралттай тэмцэх иж бүрдлийн бүрэн байдлын үзлэгийн сар тутам	Засварын талбай	ш	500'000.0	2	1,000,000	Төлөвлөгөөт жилд	

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажил	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Аргачлал, стандарт, эрх зүйн зохицуулалт
		гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүрд цэнэглэх							
9	Химийн бодис хөрсөнд асгарч, хөрсийг бохирдуулах	Химийн бодисын агуулахаас асгаралт үүсэхээс сэргийлж тогтмол ажлын байрны үзлэг хийх, аливаа дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх	Химийн бодисын агуулах		Дотоод үйл ажиллагаа			Долоо хоног бүр	Хөрс хамгаалах цөлжилтгөөс сэргийлэх тухай хууль
10	Шимт хөрс алдагдах	Шимт хөрсний овоолгийн ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах	Шимт хөрсний овоолго		Дотоод үйл ажиллагаа			Төлөвлөгөөт жилд	MNS 5916:2008
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Газрын доорх ус									
11	Газрын доорх ус бохирдох	Хаягдлын сангийн тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг хангах, тогтмол үзлэг хийх, зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх	Хаягдлын далан		Дотоод үйл ажиллагаа			Долоо хоног бүр	Усны тухай хууль
12		Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгуудын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах	Ашиглалтын худгууд		Дотоод үйл ажиллагаа			Төлөвлөгөөт жилд	
13		Газрын доорх усны геофизикийн судалгаа хийлгэх, судалгаанаас гарсан үр дүнгээс хамааран хяналтын цооног байгуулах,	Баяжуулах үйлдвэр	-	15,000,000	1	15,000,000	Төлөвлөгөөт жилд	
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Ургамал									
14	Ургамлын ургах нөхцөл багасах	Тоос босож буй зам талбайд усалгааг тогтмол хийх	Хөндөгдөх газар		Дотоод үйл ажиллагаа			Тухай бүрд	Байгалийн ургамлын тухай хууль

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажил	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Аргачлал, стандарт, эрх зүйн зохицуулалт
15	Тал хээрийн түймэр ургамлан нөмрөгт нөлөөлөх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх	Гал түймэр тохиож болох газар орчимд		Дотоод үйл ажиллагаа			Сар бүр	-
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Амьтан									
16	Үйл ажиллагаанаас зэрлэг амьтанд нөлөөлөх	Төслийн хашааны бүрэн бүтэн байдлыг хянаж мал, амьтан орохоос сэргийлж үзлэг шалгалт хийх	Төслийн хашаа	м	-	-	-	Сар бүр	Амьтны тухай хууль
17		Баяжуулах үйлдвэрийн талбай орчимд мал, амьтан эндсэн тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд ашиглах багаж, тоног төхөөрөмжийн иж бүрдэл худалдан авч, бэлэн байдлыг ханган ажиллах	Төслийн талбай	ш	1,000'000.0	1	1,000,000.0	Төлөвлөгөөт жилд	Эрүүл ахуйн дэглэм
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДЭД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮДИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ					22,500,000				

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хөх Бишрэлт ХХК нь байгаль орчинд хариуцлагатай байх, нөхөн сэргээлтийг Монгол улсын холбогдох хууль, эрх зүй, стандарт шаардлагуудад нийцүүлэхээс гадна тухайн бүс нутгийн цаг уурын онцлог, орчин нөхцөлд тохирсон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн туршлага арга зүйд тулгуурлан гүйцэтгэхийг зорин ажилладаг

Төлөвлөгөөт жилд жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэн шинээр газар хөндөөгүй тул нөхөн сэргээлт хийх шаардлага бүхий газар байхгүй тул шимт хөрсний овоолго, түүний үржил шим, хэмжээг алдагдуулахгүй байх, өнгөрсөн жилүүдэд хийгдсэн нөхөн сэргээлттэй хамаарал бүхий арга хэмжээнүүдийг төлөвлөв.

*“Цагаан Дэл” эсонш баяжуулах үйлдвэрийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт-	Шимт хөрсний овоолгийн ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах	га	-	Үйл ажиллагааны зардлаас		4-5 сард	MNS 5917:2008
2		Өнгөрсөн жилүүдэд хийгдсэн техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайнуудад шаардлагатай тохиолдолд нэмэрлэн тариалалт хийх	га	-	Үйл ажиллагааны зардлаас		Тухай бүрд	MNS 5917:2008
2024 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ НИЙТ ЗАРДАЛ					Үйл ажиллагааны зардлаас			

5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хөх Бишрэлт ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3 дах заалтууд болон 2014 оны БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын 3.3.6-д тус тус заасны дагуу Биологийн олон янз байдлыг (БОЯБ) дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний хүрээнд бид 2024 онд биотехникийн арга хэмжээ болон дүйцүүлэн нөхөн сэргээлтийн арга хэмжээнүүдийг төлөвлөж байна.

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулах	Холбогдох орон нутгийн засаг даргын тамгын газар, БОАЖГ-тай хамтран хэрэгжүүлж болох биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалах хэрэгжих газар нутаг	-	Үйл ажиллагааны зардлаас		Төлөвлөгөөт жилд	-
2	Дүйцүүлэн нөхөн сэргээлт	Орон нутгын удирдлагатай зөвшилцөн эзэнгүй орхигдсон эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Эвдэрсэн газар	-	Үйл ажиллагааны зардлаас		5-7 сард	MNS 5917:2008
3	Биотехникийн арга хэмжээ	Зэрлэг амьтанд өвс тэжээл өгөх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	-	1	300’000.0	300’000.0	Төлөвлөгөөт жилд	-
2024 ОНЫ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ					300’000			

5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд хамрагдаж байсан нэг өрхөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, тусламж үзүүлэх санал албан ёсоор гаргасан. Гэвч тухайн өрх саналыг хүлээн аваагүй бөгөөд үйлдвэрийн нөлөөллийн бүсээс нүүсэн. Иймд үйлдвэрийн нөлөөллийн бүсэд орших нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай өрх байхгүй болно.

Хүснэгт 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нийлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бачиг
1	-	2024 онд Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй	-	-	-	-	-	
2024 ОНЫ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ						ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛААС		

5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Хөх Бишрэлт” ХХК нь түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлэн ажиллахыг зорилго болгон ажилладаг. Үүний хүрээнд соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах арга хэмжээнд хувь нэмэр оруулан ажиллахыг зорьж байна.

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл одоогоор олдоогүй болно. Бид 2024 онд түүх соёлын биет болон биет бус өвийг хамгаалах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг төлөвлөв.

2024 оны БОМТ-д биет болон биет бус өвийг хамгаалах чиглэлээр 3 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Биет бус өв	Иххэт сумын ЗДТГ-тай хамтран биет болон биет бус өврүү чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх	Иххэт сум	1	10,000,000	10,000,000	Төлөвлөгөөт жилд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 27.8
2	Журам	Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг боловсруулах.	-	1	Үйл ажиллагааны зардлаас		Төлөвлөгөөт жилд	
3		Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулах сургалт орох. Журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах	-	1	Үйл ажиллагааны зардлаас		Төлөвлөгөөт жилд	
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ НИЙТ ЗАРДАЛ						10'000'000 ₮		

5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Бид “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэнэ. Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт ашиглалт, түүний хаягдал сав баглаа боодлын устгалд хяналт тавьж үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөг боловсруулав.

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлүүдийг дараах байдлаар ангилан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг нэг бүрчлэн төлөвлөсөн болно.

1. Автомашин, тээврийн хэрэгслийн осол
2. Гал түймрийн эрсдэл
3. Химийн бодис ашиглалтаас үүсэх эрсдэл
4. Хүний эрүүл мэндэд гарч болох эрсдэл

Тодорхойлсон эрсдэлүүдийг бууруулах, урьдчилан сэргийлэх 13 арга хэмжээг төлөвлөвлөн холбогдох хууль эрхзүйн бодлогын зохицуулалт, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын хамт дараах хүснэгтэд тусгав.

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй, аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хугацаа ба давтамж	Эрх зүйн зохицуулалт журам
1	Үйлдвэрийн болзошгүй осол	Баяжуулах үйлдвэрийн аваар устгах төлөвлөгөө боловсруулж, холбогдох газраар батлуулах	Үйлдвэрийн талбай	Үйл ажиллагааны зардлаас			Төлөвлөгөөт жилд	-
2		Үйлдвэрийн барилга байгууламж бүрд галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах		Үйл ажиллагааны зардлаас			Төлөвлөгөөт жилд	-
3		Үйлдвэрийн талбайд үүсэж болзошгүй аюул, эрсдлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний практик сургалтыг нийт ажилчдад орох		1	5'000'000	5'000'000	Төлөвлөгөөт жилд	-
4		Аюулгүй ажиллагааны хэлтэс ажлын байр, талбаруудад үзлэг хийж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх		12	Үйл ажиллагааны зардлаас		Сар тутам	-
5	Химийн бодисын тээвэрлэлт	Химийн бодисын агуулахаас бодис үйлдвэр лүү тээвэрлэхдээ асгаралтаас урьдчилан сэргийлж ажиллах, зааварчилгаа өгөх	Химийн бодисын тээвэрлэлтийн явцад	Үйл ажиллагааны зардлаас				
6	Химийн бодисын хадгалалт	Даралтат савласан хийг хүлээж авах шаардлагын дагуу хүлээн авч, ашиглах нөхцөлүүдийн дагуу ашиглах	Химийн бодисын агуулах	Үйл ажиллагааны зардлаас			Тухай бүрд	
7		Химийн бодисын тэмдэг тэмдэглэгээг гэмтсэн салсан тохиолдолд яаралтай дахин шинэчлэн наах		Үйл ажиллагаант зардлаас			Төлөвлөгөөт жилд	
8		Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, бүртгэл хөглөх, зарцуулалтын тайланг холбогдох байгууллага руу илгээх		Үйл ажиллагааны зардлаас			12-р сард	
9		Химийн бодисын агуулахад засвар, үйлчилгээ хийх, Агуулахын технологийн бүтэц, үзүүлэлт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дахин дүгнэлт гаргуулан авах		Үйл ажиллагаант зардлаас			Төлөвлөгөөт жилд	
10	Химийн бодисын хаягдал	Химийн бодисын сав баглаа боодлыг хадгалах, хоргүйжүүлэх, устгах журмын дагуу аюулгүй хадгалах	Баажуулах үйлдвэр	Үйл ажиллагаант зардлаас			Төлөвлөгөөт жилд	
11		Химийн бодисын сав баглаа боодлын үүсгэсэн хугацаа, тоо хэмжээ, жинг нэг бүрчлэн бүртгэх		Үйл ажиллагаант зардлаас			Төлөвлөгөөт жилд	

12		Химийн бодисын сав баглаа боодлыг аюултай ачаа хүлээн авагч буюу аюултай хог хаягдал устгуулахаар холбогдох баримт бичгийг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх		Үйл ажиллагааны зардлаас	12-р сард	
13	Галын аюул	Үйлдвэр орчимд гарч болзошгүй тал хээрийн түймэрт бэлэн байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох	Баяжуулах үйлдвэр	Үйл ажиллагаант зардлаас	Төлөвлөгөөт жилд	
2024 ОНЫ ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН НИЙТ ЗАРДАЛ				5'000'000		

5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хөх Бишрэлт ХХК нь БОМТ-ний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд Жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллахыг зорьсон.

Хөх Бишрэлт ХХК нь холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорин ажилладаг. Уг үйл ажиллагааны хүрээнд хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал гэж ангилан, ахуйн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх, дахивар хаягдлыг боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, аюултай хог хаягдлыг тусгайлан бэлдсэн агуулахад цуглуулж устгалд оруулах үйл ажиллагааг 2024 оны төлөвлөгөөнд оруулсан.

Бид холбогдох хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүний дагуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ангилан, ахуйн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх, аюултай хог хаягдлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэн ажиллахаар 2024 оны төлөвлөгөөнд тусгаж оруулсан.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн талбайн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээнүүдийг төлөвлөгөөт жилийн БОМТ-д тусган оруулав. Хог хаягдлын менежментийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын менежментийн арга хэмжээ	Цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Энгийн хог хаягдал	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ангилан ялгаж, бүртгэх, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйлдвэрийн талбайд	Дотоод үйл ажиллагаа				Төлөвлөгөөт жилд	Монгол улсын хог хаягдлын тухай хууль, түүнтэй холбоотой журам, стандартууд
2		Ахуйн буюу дахин ашиглах боломжгүй энгийн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэх гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах, бүртгэл хөтлөх,	Хог хаягдлын түр цэг	ш	150'000-	52	7'800'000	Шаардлагатай тохиолдолд	
3		Хог хаягдлын түр цэгт халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогтмол хийх		Дотоод үйл ажиллагаа				Тухай бүрд	
4		Дахин ашиглах боломжтой хаягдлыг /хаягдал мод, төмөр/ өрхийн хэрэгцээнд ашиглах зориулалтаар орон нутгийн малчин иргэдэд олгох	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа				Төлөвлөгөөт жилд	
5		Хог хаягдлын цэгт ангилан ялгалтыг сайжруулах, шаардлагатай газруудад хогийн сав байрлуулах	Төслийн талбай	ш	70,000	20	1,400,000	Төлөвлөгөөт жилд	
6		Хог хаягдлын ангилан ялгалтад хяналт тавих үзлэг шалгалт хийх	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа				Төлөвлөгөөт жилд	
7		Компанийн багц дотоод сургалтын хүрээнд нийт ажилчдад хог хаягдалтай холбоотой сургалт зохион байгуулах	Төслийн талбай	-	5,000,000	1	5,000,000	Төлөвлөгөөт жилд	
8		Төслийн талбайд байрлах бүх хогийн савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухай бүрд солих	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа				Шаардлагатай тохиолдолд	
9		Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал хадгалах сав, талбайг холбогдох шаардлага хангасан байдлаар шинэчлэх, сайжруулах	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа				

10		Аюултай хог хаягдал тээвэрлэх болон устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулах, аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгч акт үйлдэх	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа		Төлөвлөгөөт жилд
11		Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хүлээлгэж өгөх, устгалд оруулах	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа		Шаардлагатай тохиолдолд
12		Техник тоног төхөөрөмжийн ашигласан хаягдал тосыг үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тосолгоонд дахин ашиглах, тухай бүр ашиглалтын бүртгэл хөтлөх	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа		Шаардлагатай тохиолдолд
13		Үйлдвэрт ашиглах химийн бодисын сав баглаа боодлыг цэвэрлэх, ангилан төрөлжүүлж бүртгэх, түр цэгт хадгалах, устгах үйлдвэрт нийлүүлэх	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа		Төлөвлөгөөт жилд
14		Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авах	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа		Төлөвлөгөөт жилд
15	Хог хаягдлын тоо бүртгэл хөтлөх	Үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, БОХ тайланд тусгаж сумын захиргаанд хүргүүлднэ	Төслийн талбай	Дотоод үйл ажиллагаа	-	12 сард
2024 ОНЫ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН НИЙТ ЗАРДАЛ				14,200,000		

5.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Бид төлөвлөгөөт жилд удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд нийт 7 төсөвт болон төсөвт бус арга хэмжээ төлөвлөөд байна. Тухайн арга хэмжээнүүдийг доорх хүсэнгтээс харна уу.

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан
1	Зөвлөх үйлчилгээний ААН-тэй гэрээлэх	800,000	Төлөвлөгөөт жилд	Баяжуулах үйлдвэр
2	Ногоон байгууламж	Дотоод үйл ажиллагаа	Төлөвлөгөөт жилд	
3	Төслийн ус ашиглах дүгнэлт авах, гэрээ байгуулан ажиллах		Төлөвлөгөөт жилд	
4	Төслийн хаягдал усны дүгнэлт авах, гэрээ байгуулах, зөвшөөрөл авах, холбогдох төлбөрийг төлөх		Төлөвлөгөөт жилд	
5	Аймгийн Засаг даргаар тээврийн замын маршрутыг тогтоолгох		Төлөвлөгөөт жилд	
6	Экологийн паспорт хөтлөх		Төлөвлөгөөт жилд	
7	Орон нутаг, хамтын ажиллагаа		Төлөвлөгөөт жилд	
2024 ОНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ			800,000	

5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, тэдгээрийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал болон холбогдон гарах зардлуудыг урьдчилан тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулан хүснэгт 10-д нэгтгэн үзүүлэв.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг хуулиудын дагуу төсөл хэрэгжүүлэгч нь орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг хариуцан гаргаж, аливаа ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу хийж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсад итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүнг тухайн жилийн тайландаа тусган ажиллахаас гадна улирал тутам ус, хөрсний дээжний шинжилгээний хариуг зохих газруудад хүргүүлэн ажиллана.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Экологийн бүрдэл хэсгүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн нэр байршил		Хугацаа ба Давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Зөвшөөрөгдөх хэмжээ/Баримтлах стандарт
			Хяналт шинжилгээний цэгүүдийн дугаар/код	Дээж авах байршил, координат /49N /					
1	Агаар	Хүчилтөрөгч (O ₂); Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO); Азотын давхар исэл (NO ₂); Циант устөрөгч (HCN); Хүхэрлэг хий (SO ₂); Агаар дах PM10, хэмжээтэй тоосонцор; Агаар дах PM2.5 хэмжээтэй тоосонцор; Дуу чимээ;	AQD-1	Тогтсон цэгээс	Улирал тутам	4 удаа	250*000	3,000,000.00	Агаарын чанар. MNS 4585:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 5885:2008 Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам MNS 17.2.3.16-88 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 4048:88
2			AQD-2	Тогтсон цэгээс			250*000		
3			AQD-3	Тогтсон цэгээс			250*000		
4	Хөрс	рН, Хөнгөнцагаан/Al/; Калци/Ca/; Магни/Mg/; Кали/K/; Төмөр нийт/Fetotal/; Хүнцэл/As/; Бари/Ba/; Берилли/Be/; Бисмут/Bi/; Кадми/Cd/; Кобальт/Co/; Хром/Cr/; Зэс/Cu/; Лантан/La/; Лити/Li/; Манган/Mn/; Молбиден/Mo/; Никель/Ni/; Фосфор/P/; Хар тугалга/Pb/; Сурьма/Sb/; Селен/Se/; Стронци/Sr/; Титан/Ti/; Ванади/V/; Иттрий/Y/; Цайр/Zn/; Циркони/Zr/;	SMP-1	Тогтсон цэгээс	Улирал тутам	4 удаа	350,000	4,200,000.00	MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 3298-90. Хөрсний дээжлэлтэд тавих ерөнхий шаардлагууд; Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 3297-91
5			SMP-2	Тогтсон цэгээс			350,000		
6			SMP-3	Тогтсон цэгээс			350,000		
7	Гүний ус	рН, Кали, /K+/; Натри, /Na+/; Кальци, /Ca2+/; Магни, /Mg2+/; Хлорид, /Cl-/; Нитрит, /NO2-/; Нитрат, /NO3-/; Карбонат, /CO32-/; Гидрокарбонат, /HCO32-/; Нийт хатууллаг, /Нийт хатууллаг/; Хуурай үлдэгдэл, /TDS/; Мөнгө, /Ag/; Хөнгөнцагаан, /Al/; Мышьяк, /As/; Бари, /Ba/; Кадми, /Cd/; Кобальт, /Co/; Хром, /Cr/; Зэс, /Cu/; Төмөр, /Fe/; Манган, /Mn/; Молибден, /Mo/; Никель, /Ni/;	WMP-1	Тогтсон цэгээс	Улирал тутам	4 удаа	500,000	6*000,000.00	Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6148:2010 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS 4586:1998 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага,
8			WMP-2	Тогтсон цэгээс			500,000		
9			WMP-3	Тогтсон цэгээс			500,000		

		Хартугалга, /Pb/; Цайр, /Zn/; Уран, /U/							чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2018 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага. MNS 4943:2015
2024 ОНЫ ОХШХ-ИЙН НИЙТ ЗАРДАЛ			13,200,000						

Хүснэгт 11. ОХШХ-ийн хүрээнд хийгдэх ажлууд

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа Давтамж	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
1	Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний хүрээнд ус, хөрс, агаар, ургамал, амьтны дээжлэлт, хэмжилт, шинжилгээ хийх хяналтын цэгүүдийн байршлыг тодорхойлох, тухайн цэгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, кодлол болон дугаарлалтын систем бий болгох	Төлөвлөгөөт жилд	Агаар
2	Агаарын хэмжилтийг зөөврийн багажаар гүйцэтгэх, үр дүнг боловсруулах	Жилд 2 удаа	Агаар
3	Хөрсний дээжлэлтийг гүйцэтгэж лабораториудад харгалзах үзүүлэлтүүдээр шинжлүүлэх	Жилд 2 удаа	Хөрс
4	Ундны усны дээж авч химийн болон бактерлогийн үзүүлэлтийг шинжлүүлэх	Жилд 2 удаа	Ундны ус

5.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллаж, нээлттэй байх, хамтран ажиллах зарчмыг “Хөх Бишрэлт” ХХК баримтан ажиллана.

2024 онд бид нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээний хүрээнд доорх арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг танилцуулах	Дотоод үйл ажиллагаа	6-9 сард	Байгаль орчны хэлтэс
2	Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон БОМТ, ОХШХ-ийн талаарх мэдээллүүдийг танилцуулах	Дотоод үйл ажиллагаа	Тогтмол	
2024 ОНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ		Дотоод үйл ажиллагаа		